



## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/Н

Арвайхээр

### Г Ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/520 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 30 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


I. Монгол Улсад Ковид-19 цар тахлын халдвар дотооддоо тархаж, Гамшгаас хамгаалах эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээ авч байгаатай холбогдуулан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зарим эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын цагийн хуваарьт 2021 оны 02 дүгээр сарын 08-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд өөрчлөлт оруулсугай

II. Ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж буй дээрх хугацаанд ажлын хариуцлагаа өндөрсгөж, амбулатори, стационарын тусламж үйлчилгээг хэвийн явуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлж ажиллахыг нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.


III. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зарим тасаг, нэгжүүдэд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хуваарийг долоо хоног бүр маягтын дагуу гаргаж, гарын үсгээр баталгаажуулж Хүний нөөцийн албанд мэдэгдэж ажиллахыг тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

IV. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал (Д.Мөнхнасан), Хүний нөөц, сургалт хөгжлийн албаны дарга (Л.Алтантөгс), Сувилахуйн албаны дарга (Ц.Төмөрцоож) нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Э.ХҮДЭРЧУЛУУН



АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАНТАЙ ХОЛБОГДОН  
ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

1. Монгол Улсад Ковид-19 цар тахлын халдвар дотооддоо тархаж, Гамшгаас хамгаалах эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээ авч байгаатай холбогдуулан эмнэлгийн эрсдлийг тодорхойлон, хүний нөөцийг тараан байрлуулах зорилгоор авч хэрэгжүүлж буй ажил тул эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хариуцлагатай байна.

2. Амбулатори, стационарын тусламж үйлчилгээг хэвийн явуулж, хүлээгдэл чирэгдэл үүсгэхгүй байна.

3. Мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэндээ өөрийн хариуцаж байгаа ажил, эмчилгээ оношилгооны шаардлагатай асуудлыг утсаар болон цахимаар дараагийн ээлжийн эмч, эмнэлгийн ажилтанд хүлээлгэн өгнө. Хүнд өвчтөний асуудлыг өвчтөний түүхэнд тэмдэглэх, болон цахимаар дараагийн эмчдээ хүлээлгэн өгнө.

4. Ковид-19 цар тахлын халдварын үед дайчлагдан ажиллах хуваарийн дагуу тухайн мэргэжлийн баг дуудагдах тохиолдолд идэвхжин дуудагдан ирж ажиллана.

5. Гэрээр, цахимаар ажлаа хийх үед хариуцлагатай байх, Үүнд:

- Цахимаар ажлын цагийг бүртгэнэ. Өдөр бүр 09:00, 14:00 цагт ШУБ-ын жижүүрт бүртгүүлнэ.
- Эмч нарын хурал, хичээл болон Тасгийн эрхлэгч, Сувилахуйн арга зүйчдийн хурал, шуурхай хуралд гэрээсээ цахимаар холбогдож оролцоно.
- Зөвхөн гэртээ байх, гар утсаа салгахгүй, шаардлагатай тохиолдолд дуудагдан ажиллана.
- Хөдөө сум, бусад аймаг хот руу зорчихгүй байх.
- Халдварын бүсэд болон хөл хөдөлгөөн ихтэй газраар зорчихгүй байх, халдвараас сэргийлэх
- Хүний нөөцөд эмнэлгийн гадна байгаа чухал мэргэжилтэн гэдгээ ухамсарлах

6. Тасгийн хуваарийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтэн гарын үсэг зурснаар баталгаажна.